



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

┌ Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ┐
шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга
хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 34 дүгээр өргөтгөсөн шуурхай хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны A/108 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг үйлчилгээний алба, байр ашиглалтын албаны дарга нар болон менежерүүдэд тус тус үүрэг болгосугай.

2. “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтэд үе шаттайгаар хуваарь гарган хяналт тавьж тайлагнаж ажиллахыг дотоод хяналт хариуцсан ажилтан /Б.Хэнмэдэх/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг Орлогч дарга /Ч.Однасан, Б.Галмандах/, Захиргаа, санхүүгийн хэлтэс /Ч.Шинэчимэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

C:\Users\Desktop\A tushaal.docx

1150500031